

Нэгэн хошууны хоёр хийдийн дөрвөлжин үсгийн гоёл

Ринчинсамбуугийн ОТГОНБААТАР\*  
Монгол Улс, Улаанбаатар,  
Шинжлэх ухааны академийн  
Хэл зохиолын хүрээлэнгийн  
Төвөд судлалын салбар

**Received:** Aug 08, 2025 | **Revised:** Oct 31, 2025 | **Accepted:** Nov 04, 2025

**Хураангуй:** Монголын дөрвөлжин үсгийн дурсгалыг их гүрнээс хойш хэрхэн уламжилсныг хорьдугаар зууны эхэн үе хүртэл бид хуучин дурсгал хэмээн үзэж анхааран цуглуулж нягтлаад эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулах нь зохистой. Үүнд сүм хийдийн хана туурга, хаалга үүд, сав шүүгээний нүүр бараг эдлэл хэрэглэлийн зүйл дээрх гоёл чимэглэл онцгой байр суурийг эзэлнэ. Энэ удаа түүний нэг болох нэг хошууны хоёр хийдийн хаалга хатавчны дөрвөлжин үсгээр төвөд хэлээр бичсэн үг үсгийг тайлбарлан судалгааны эргэлтэд оруулж байна. Энэхүү хоёр чимэглэлийн үсэг бичээс нь өвөрмөц сонин онцлогтой болох тухай дэлгэрүүлэн өгүүлж, гэрэл зургийг хавсаргасан болно.

**Түлхүүр үг:** Дөрвөлжин үсэг, сүм хийдийн гоёл, хаалга хатавчны бичээс

**Square Script Decoration of Two Temples  
Belonged to One Banner**

**OTGONBAATAR Rinchinsambuu**

*The Sector of the Tibetan Studies,  
Institute of Language and Literature,  
Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** It is necessary to consider the Mongolian square script monuments inherited from the great empire period to early 20th century as an old monument and pay attention, collect, check and put into the scientific research circulation. In this regard, the temple walls, entrance doors, cabinet and furniture front sides, and other various item decorations have special significances. This time, we are decoding the words written by a square script in the Tibetan language on the door and nearby areas of two temples belonging to one banner as an example and putting them into the scientific research circulation. Hence the letters and inscriptions have peculiar and worth of interest features, we are talking in detail and relevant photos had been attached.

---

\* © Р.Отгонбаатар 2025  
Email: ongqud@gmail.com

**Key words:** *Square script, monastery and temple decorations, inscriptions on the door and nearby areas*

## 1. Удиртгал

Аль ч газрын сүм хийдийг сүсэгтэн олон ур ухааныхаа дээдийг зориулан барьж бүтээдэг уламжлалтай. Ялангуяа их хөлгөний шашинтай монгол төвөдийн ард олон хэдэн зуун жилийн турш хэдэн мянган сүм хийдийг барьж босгоод дотор гадар ялгалгүй уран гоёмсог угалз хээгээр чимэхээс гадна утга төгөлдөр тарнийн үсэг ерөөл зэргийг хана туурга хаалга үүдэндээ олон зүйл үсгээр бичдэг ёс заншилтай. Үүнд ланз соёмбо, төвөд монгол үсэг бичгийг түгээмэл хэрэглэхээс гадна монголын Их юань улсын эзэн хаан Хубилай сэцний зарлигаар сажа нутгийн эрдэмтэн Пагва лам Лодойжалцаны зохиосон Их монголын дөрвөлжин үсгээр чимэглэл болгон бичдэг эрхэм заншил тогтсон билээ. Ийм дурсгалт бичигтэй сүм хийд эртнээс эдүгээ болтол Балтын тэнгисийн эргээс урагшлаад балба төвөд энэтхэгийн нутаг хүртэл олон тоотой буй.

Үүнд манай монгол нутагт байсан хэдэн зуун сүм хийдээс дөрвөлжин үсгээр утга уянга, бэлэг дэмбэрэлтэй ерөөл бичиж гоёсон сүм хийд нэлээд олон байсан аж. Хэдийгээр сүм хийдийг ная орчим жилийн тэртээ ихэнхийг нь үгүй хийсэн боловч өнөө хэр миний мэдэж буйгаар ийм дөрвөлжин үсгийн гоёл чимэглэлтэй хуучин сүм хийд цөөн хэд үлдэж хоцорсон байна. Энд нэгэн удаагийн явдлаар хоёр сүм хийдээр очихдоо үзэж харсан үсэг бичгийн ялангуяа дөрвөлжин үсгийн нандин дурсгал болох бичээсийн тухайд боломжийн хэрээр нутгийн ардууд, нийт сүсэгтэн олон, соёл түүхээ сонирхогчдод зориулан танилцуулья. Энэ хоёр хийд хэд хэдэн өртөө газрын тэртээд нэлээд зайдуу оршдог юм. Хэдий тийм боловч Чин улсын үеийн Халхын умард замын зүүн гарын умард хошуу (Шархүү, 1984: 154-155) буюу Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу нь угаас томоохон нутагтай уламжлал ёсоор урдаас хойш сунгасан мэт учир эрт цагт нэгэн хошууны өмнөд хойд захад орших говь хангайд орших хоёр хийд гэхэд болно.

Үүнд юуны өмнө хоёул адилхан ард олны дунд Сангийн далайн хийд гэдэг нутгийн нэрээр алдаршсаныг онц анхаарах хэрэгтэй. Хуучин цагт ч энэ хоёр хийдийг өмнөхийг нь Говь сангийн далайн хийд буюу Номгоны хийд гэх ба Эрдэнэдалайн хийдийг нь хойд Сангийн далайн хийд гэж ялган нэрлэдэг байжээ. Бас учир мэдэх дээд үеийн хүмүүс бол өмнө хийд нь харьцангуй эрт байгуулагдсан Манжийн эзэн хаанаас нэр шагнуулсан гэх бөгөөд хойд хийд нь нэлээд хожим байгуулагдаж монголынхоо Богд гэгээнээс төсөөтэй нэр авсан гэлцдэг байж.

## 2. Судалгааны арга, эх хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд эрт цагийн Говь түшээ гүний хийдийн урд хойд захын хоёр хийд дээр хээрийн судалгаа хийж, уг сүм хийдийн ерөнхий байдал, хаалга хатавчны гэрэл зургийг тусгайлан авч, газар дээр нь гар бичмэлээр сийрүүлэн сэргээн бичиж, нягтлан бичиж тулган шалгав. Судалгааны эх хэрэглэгдэхүүнээр уг сүм хийдийн онцлох хэсгийн гэрэл зургийг голлон ашигласан болно. Мөн хоёр хийдийн түүхэнд холбогдох судалгааны ном зохиол зэргийг үзэж ашиглав.

## 3. Судалгааны хэсэг

### Нэг. Номгоны хийд буюу Говь сангийн далайн хийд

Чин улсын үеийн Халхын умард замын зүүн гарын умард хошуу буюу Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу одоогийн Өмнөговь аймгийн Номгон суманд нэгэн томоохон хийдийн суурь буурь дээр тав зургаан сүм хуучин хэвээрээ шахам хадгалагдан үлджээ. Энэхүү хийдийг гурван зуу орчим жилийн өмнө байгуулж эхэлсэн гэдэг. Харин уул хийдийн хуучин хаяг үгүй болсон бололтой. Гэвч Чин улсын хаанаас Шашныг хөгжүүлэгч сүм хэмээн нэр шагнав гэж “Монголын хүрээ хийдийн түүх” (Банзрагч, 2004: 46) номд бичсэн билээ. Уг хийдийг нэгэн эрдэмтэй бадарчин хүн аялан явж байгаад рашаан булаг нээж олсон тул түүний дэргэд байгуулсан гэж нутгийн хүмүүс хуучилсаар байна. Үнэхээр хийдийнхээ хэрэм хашааны баруун урд өнцгөөс төдийлөн холгүй амны усаа авахуйц газар амтат рашаан булаг одоо ч дэвлэн оргилсоор байна. Нутгийн хүмүүс сумын төвийнхөө өмнө орших энэхүү ариун сайхан рашаанаа томоохон төмөр хайс хашаагаар хамгаалан одоо ч ууж хүртсээр байдаг аж. Энэ хийд сүм эрт цагт арав гаруй дуган сүмтэй, хэд хэдэн дацантай, олон жастай хагас мянга орчим хуврагтай томоохон хийд байсан хэмээмүй. Одоо ч энэ хийдийн хашаа хүрэн дотор болон гадна талд хуучин цагийн сүм дуган барилга байшингийн үлдэгдэл арав орчим тооны орон суурин байсаар буй. Хийдийн гаднах хуучин барилгаас сумын төвийн алба амины сууц болон үлдсэн нь ч бий гэнэ. Харин одоогийн хэрэм дотор буй хэдэн дуган бараг хуучин төлөвөө хадгалсан шахам үлджээ. Хоймор байх нэгэн сүмийн гадна талд бадамлянхуа цэцэг, хөндлөн очроор эргэн тойрон хөмсгийг гоёлж түүнийхээ дотуур нь соёмбо тэмдэг олныг зэрэгцүүлэн дээд хэсгийг бүхэлд нь хүрээлэн гоёлсон байдал ч хэвээр буй. Эдгээр чимэглэлийг шавар хэвэнд товгор цутгаж урласан онцлогтой. Энэ дуганы өмнө талд байх гол дуган буюу цогчин байсан бололтой хоёр давхар шинэчлэн сэргээн зассан сүмийн үүдэнд дөрвөлжин үсгээр гоёлсон хоёр хатавчны багана модыг солихоос нь өмнө үзсэн гэж нутгийн нэгэн хүн мэдээлэв. Харин одоо хамгийн зүүн өмнө талын томоохон дуганы үүдэнд дөрвөлжин үсгийн эртний бичээс нь хэвээр байгааг онцлон тэмдэглэе.

Энэ бол их тал говийн дунд үлдэж хоцорсон эрхэм чухаг дурсгалын нэг мөн гэж хэл бичгийн мэргэжилтэй хүний хувьд сайшаамаар байна. Бичсэн үсэг үгсийн хувьд ч өвөрмөц сайхан дурсгал мөн. Учир нь ийм дөрвөлжин үсгийн гоёлтой хаалга үүд, хатавч баганатай сүм хийд хэдэн арвыг ажиж үзэхэд болон өнөө хэр үгүй болсон хийд хийгээд одоо ч оршин сүндэрлэж буй сүм хийдийн бичээсийн өдий төдий гэрэл зураг зэргийн дунд миний хувьд үүний адил үсэг цагаан толгой бүхий нь огт тохиолдсонгүй. Юун хэмээвээс дурдан буй сүмийн гадна хаалганы хоёр хатавчинд нэгэн шад “Дашийвар жүржиг” /**bkra shis par gyur cig**/ буюу “Өлзий хутаг орших болтугай” гэсэн ерөөлийг мөн үгсээ бичсэн дөрвөлжин үсгийнхээ цагаан толгойн гучин үсгийг дээд хоёр этгээдэд нь аятайхан хуваан байрлуулж бичсэн байна. Баруун хатавчны дээд талаас бярга тэмдгийн дараа хоёр ойрхон шад тавьж эхлээд “га ха га /нг/а” гээд нэгдүгээр аймгийн дөрвөн үсгийн дараа ойрхон хоёр шад, “жа ча жа ня” гэсэн хоёрдугаар аймгийн дөрвөн үсгийг бичээд холхон хоёр шад, “да та да на” гэсэн гуравдугаар аймгийн дөрвөн үсгийг бичээд ойрхон хоёр шад, “ба па ба ма” гэсэн дөрөвдүгээр аймгийн дөрвөн үсгийн доор холхон хоёр шад татаад “дашийвар жүржиг” хэмээн бичээд ойрхон хоёр шад татаж төгсгөжээ. Нөгөө тал буюу зүүн хатавчнаа мөн бярга тэмдгээр эхэлж хоёр ойрхон шад, “за ца за ва”, “ша са а яа” гэсэн тавдугаар болон зургадугаар аймгийн найман үсгийг баруун талтайгаа эн тэнцүүлэн холхон хоёр шад, түүний доор “ра ла ша са” гэсэн долдугаар аймгийн дөрвөн үсгийн доор хоёр ойрхон шад, дахин “ха, а” хэмээх хагас аймаг буюу наймдугаар аймгийн хоёр үсгийн дараа холхон хоёр шад татаж басхүү “Дашийвар жүржиг” хэмээх ерөөлөө бичээд хоёр ойрхон шад татахад үлэмжхэн зай

үлдсэн учир дээр заагласан холхон зайгаа авч “Гэо” /dge'o/ буюу “Буян болой” гэсэн үгийг уламжлал дагуу бичиж хоёр хатавчны зайг яг таг тааруулан бичиж хоёр ойрхон шад, мөн зайтайхан хоёр ойрхон шад нийт дөрвөн шад татаж тэнцүүлэн төгсгөсөн байна. Тэнд бичсэн үсэг, үгийг мөр зэрэгцүүлэн үзүүлбэл:

*Баруун талын хатавчны бичээс*

**ka kha ga nga// ca cha ja nya// ta tha da na// pa pha ba ma// bkra shis par gyur cig//**

*Зүүн талын хатавчны бичээс*

**tsha tsha dza wa// zha sa 'a ya// ra la sha sa// ha aa// bkra shis par gyur cig// dge'o//**

Энэ бол аль ч дөрвөлжин үсгийн гоёлтой сүм хийдийн гадна дотно хаалга хатавчинд тохиолддоггүй маш өвөрмөц шийдэлтэй бичээс юм. Эрт эдүгээ аль ч үед төвөд монгол хэл бичигтэн хүн бүр дөрвөлжин үсгийг төдийлөн мэддэггүй бөгөөд нэлээд боловсролтой хүмүүс буюу үсэг бичгийн мэргэжилд сонирхолтой цөөн тооны хүн л уншиж бичиж оролддог байсан билээ. Ялангуяа жирийн лам хуврагууд дөрвөлжин үсгээр гоёлон бичсэнийг гадарлах боловч чухам ямархан ерөөл билэгтэй үгс байгааг шууд уншиж ойлгох нь бас л бэрхшээлтэй. Харин энэхүү бичээсийг бол хичээн оролдсон төвөд хэл бичигтэй хувраг хүн төдийгүй төвөд үсэг ном төсөөлөх хар хүн ч уншиж ойлгож болох талтай. Учир нь хоёр гурван зуун жилийн тэртээх монголчууд эр эм, лам харгүй бараг хүн бүр гадарладаг байсан шахам “Дашийвар жүржиг” буюу “Өлзий хутаг орших болтугай” гэсэн ерөөлийн үгсийг бичжээ. Чингэхдээ уг өгүүлбэрийг бичсэн толгой үсгийг нь суралцахад зориулсан мэт дээр нь бичиж өгсөнд оршино. Үүнийг урласан ухаант мэргэд хажуугийн дуганууд болон сүм хийдийнхээ дотор талд ямархан үг үсгээр юу бичиж яаж гоёлсныг өнөө бид тааварлан хэлэх аргагүй буй. Бусад газрын бичээсийг үүгээр жишиж үлгэрлэн уншиж ойлгох, бага хөвгүүд урамшиж оролдох түлхүүр болгож урласан өвгөдийн ухаан ч байж болзошгүй. Энэ мэт мэргэн өвөг дээдсийн өмнө хойч үеийнхэн мэхийн ёслох учиртай болой. Бас адар таазны гоёлд Гүнсэнхорло (kun bzang 'khor lo) хэмээх зүг бүрд сүлжин уншдаг шүлэг мэтийг бичсэн ул мөрийн зах зух үлдэж хоцорсон байна.

Бүхэлдээ уг сүм хийдийн хаалга үүд нь маш сайн давхар давхар зузаан яс модтой бөгөөд гадна талын хүрээг дөрвөлжлөн ухаад дотор хүрээнд нь бадам лянхуа сийлж өнгө ялган будаад тотгон дээгүүр нь хөндлөн ланз үсгээр алдартай тарни болон дөрвөлжин үсэгтэй хэсгээ бөөрөнхий чимэг хажны дотор басхүү давхар модон ирмэгийн дунд зүмбэрдэн товойлгож бичээд будсан байна. Харин цагийн аясаар хуучирч зарим хэсэгт өчүүхэн халцарч унасныг сэргээн засахад хүрвэл уг байдлыг хадгалан нягт нямбай хандах хэрэгтэй билээ. Энэ бичээсийн зүүн дээд бярга халцарч үгүй болсон байна. Энэ мэт түүх соёлын дурсгалыг тухайн үеийнх нь эд өлөг, эрдэс будгаар сэргээн засах ёстойг эрхбиш мэргэжлийн хүмүүс мэднэ. Гэвч сүүлийн үед сайхан сэтгэлээр сүм хийдийг сэргээн засагч сүсэгтэн олон энэ мэт бичээсийн учир начрыг нарийн тодорхой мэдэхгүйгээс угалз хээ мэт болгон зөв буруу бөглөж тагласан явдал ч тохиолдоно. Угтаа тусгай үсэг бичгийн боловсрол мэдлэг шаардах зүйлийг огт мэдэхгүй хүн сэргээн зурж бичсэнээс ямар үг үсгийг ямархан аргаар эвхмэл зурлага ашиглаж бүтээснийг тоймлоход ч хэцүү төвөгтэй, сэргээж унших боломжгүй болтол шахам будсан зүйл гадаад дотоодод нэг хоёр сүм дээр ажиглагдсан билээ. Иймэрхүү зүйлийг уг түүх соёлын дурсгалт газар

нутагладаг, түүнийг өөд нь татахад санаа тавьдаг орон нутгийнхан, түүний соёлын зүтгэлтэн, сүсэгтэн олон ч анхаарууштай байна.

Хувийн цуглуулгад буй зургийн хэсгээс сонирхуулбал:

Зураг №1. Уг сүмийн ерөнхий байдлаас нүүрийн хэсэг



Зураг №2. Сүмийн хаалга



Зураг №3. Сүмийн хаалганы хатавчийн бичигтэй хэсгийн жишээ



### Хоёр. Эрдэнэдалайн хийд буюу Сангийн далайн хийд

Чин улсын үеийн Халхын умард замын зүүн гарын умард хошуу буюу Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу одоогийн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт Хар бутан дэнж гэдэг газар мөн Сангийн далай хийдийг үүсгэн байгуулжээ. Богд Жавзандамба хутагтаас Дамбадаржайлин хэмээх нэр шагнасан гэдэг. Уг сүмийн хуучин хаяг юм уу арай хожим хийсэн нь үл мэдэгдэх нэг хаяг одоо ч сүмийнхээ гол хаалганы дээр байна. Тэр нь төвөдөөр Дамбадаржайлин /*bstan pa dar rgyas gling*/, монгол бичгээр Шашин дэлгэрэх хийд гэсэн байдаг. Гэвч энэ хаяг нь бүр сүүл үед шинээр хийсэн бус шинэ үсэг хэрэглэж эхэлсэн үед буюу хуучин цагийн урчууд байх цагт хуучин хаягийг засамжлан шинэ үсгийг оролцуулан урласан ч байж магадгүй гэмээр юм. Учир нь дээд хөмсөг тотгыг хоёр зах нь дэрвэгэр угалзтай хүрээнээ чандмань эрдэнэ голлуулан найман тахил сийлжээ. Мөн хоёр хажуугаар нь хатан сүйх хаан бугуйвчийг угалзан дунд сийлбэрлэн урласан байна. Доод этгээдэд хашлага хүрээний дунд задгай бадам урлаж бүхэлд нь өнгө ялган будсан юм.

Энэ хийд нь дөрвөн аймаг дөрвөн дацантай, гурван зуу гаруй ламтай, цам майдар бүхий арав гаруй дуган суваргатай байсан боловч одоогоор ганц л том дуган үлдэж хоцорчээ. Харин хожим нэлээд том хашлага хэрмээр хүрээлэн, дотор нь нэгэн шинэ байшин барьжээ. Хийдийн өмнө хоёр суварга буй. Хоёр давхар томоохон сүм бөгөөд дэрвэгэр дээврийг нэлээдхэн илүү алслуулан тавьж олон баганаар эргэн тойрон хөндий хүрээлсэн хийгээд сүмийн хана олон баганын завсраар эргэлчин мөргөлчид хурц нар ширүүн бороог ажрахгүй гороолох дүүрэн боломжтой бүтээжээ. Энэ сайхан сүм хийд дээр зуу гаруй жилийн тэртээ Арван гуравдугаар далай лам монголд морилон ирэхдээ буудаллаж байсан гэдэг. Үүнээс болов уу нутгийн зарим хүмүүсийн яриагаар маршал

Чойбалсан гуай нэг удаа очихдоо нураах хэрэггүй хэмээн хэлсний буянаар ч юм уу үлдэж хоцорсон ганц дуган хэмээдэг аж. Энэ сүмийн гол үүдний гадна талын дөрвөн хавтас хаалганы дөрвөн баганын хамар тус бүр дээр дөрвөлжин үсгээр эвхмэллэн бичсэн хэдэн шад бичээс буй. Уул дөрвөн баганын дотор этгээдэд бүлтгэр нуух товойлгон урласан тул бичгийн хэсэг барагтай юм шүргэхэд халцрахааргүй учир удаан жил бараг хэвээр хадгалагдан үлджээ. Уг бүлтгэр нуух хөмсгөн дотроо үсэг тус бүрийн гадуур товгор зүмбэрдэж нуух хийгээд үсгээ алтаар будсан байжээ. Хоёр нугаламтай бяргаар эхлүүлэн хоёр шад татаад төвөдийн долоон үет мөр шад бүрийн төгсгөл болон эхлэлд дөрвөлжин бичгийн заншил ёсоор хошоод хөндлөн шад тавьсан байна. Дөрвөн босоо баганынхаа дунд талын хоёр хамар баганын доод хэсэгт тус бүр өндөрхөн зай үлдээж цэцэгтэй ваарыг нэгэн адил тэнцүүлэн зуржээ. Мөн хоёр хатавчны баганын хөлд бага шиг зай үлдээгээд тус бүр ширээ зурж хөл болгосон нь тун тохиромжтой чимэг зураг болсон байна. Уул дөрвөн баганын дотор байх дөрвөн хавтас хаалгыг гурван жижиг таслал, хоёр том тав таван бүлтгэр нуух бүхий нүдтэй урлаад голын хошоод том нүд бүрд найман тахилыг нэжгээдээр зурж урласан бөгөөд дээр доор дундах жижиг нүд цонх мэтэд нь угалзан дунд нэгэн адил зургаан том зургаан жижиг дэлбээт цэцгийг хоёр талд нь угалзтай зуржээ. Харин найман тахилаа дөрвөлжин үсгийн нэгэн адил зүмбэрдэн товойлгож өнгө ялган будсан байна.

Тэрхүү хамар баганандаа дөрвөлжин үсгээр хоёр бадаг найман мөр шүлгийг дөрвөн босоо эгнүүлэн бичсэнийг галиглан буулгавал:

**bdag dang gzhan gyi dus gsum dang/  
 'brel ba'i tshogs gnyis la brten nas/  
 rgyal ba blo bzang grags pa yi/  
 bstan pa yun ring 'bar gyur cig /  
 chos kyi rgyal po tsong kha pa'i/  
 chos tshul rnam par 'phel ba la/  
 bgegs kyi mtshan ma zhi ba dang/  
 mthun rkyen ma lus tshang bar shog /bkra shis shog /dge'o/**

гэжээ. Үүнийг утгачлан орчуулбал:

*“Өөр ба бусдын гурван цаг[ууд] лугаа*

*Барилдахын хоёр чуулганд шүтээд*

*Ялуугсан богд Сумадигирдигийн*

*Шашин өнө удаан дэлгэрэх болтугай.*

*Номын богд Зонховын*

*Номын ёс тийн дэлгэрэхүйд*

*Тотгорын бэлгэ амарлих хийгээд*

*Зохилдохын нөхцөл бүхэн бүтэх болтугай.”* гэсэн утгатай. Эртний хуучин орчуулгад толгойлон шүлэглэснийг үзүүлбэл:

*“Өөр бусад гурван цагуудын*

*Үйлдэгч хоёр чуулган бээр*

*Үлэмжит богд эрдэнэ*

*Үнэн шажин өнө бадар.*

*Номын хаан богд Зонховын*

*Номын ёсон маш арвидан*

*Номын түйтгэр ёрс амарлин*

*Номын найрал төгс болтугай”* (Галлуу, Жарантай, 1986: 870-871) гэсэн нь “Данбарма” (bstan ’bar ma) буюу Шашин дэлгэрэхүй, Шашин бадрангуй гэдэг алдартай ерөөлийн төгсгөлийн найман шад хоёр бадаг шүлгийг бичжээ. Энэ хоёр бадаг шүлэг зарим ерөөлийн төгсгөлд өмнө хойноо орсон байх нь элбэг.

Зураг №4. Сүмийн хаалганы бичээсийн ерөнхий байдал



Зураг №5. Сүмийн хаалганы бичээсийг тодруулсан жишээ



Зураг №6. Бичээс бүхий сүмийн хаяг хийгээд ерөнхий байдал





#### 4. Дүгнэлт

Манай улсын эрдэмтэн судлаачид гол төлөв дөрвөлжин үсгийн эртний монгол хэлний дурсгал дээр анхааран ажилласан боловч хожуу үеийн бага сага дурсгал түүний дотор дээрх маягийн сүм хийдийн дөрвөлжин үсгээр төвөд хэлээрх жижиг бичээсийг огт анзаараагүй мэт. Тийм учраас энэ удаад урьд өмнө судалгааны эргэлтэд хараахан ороогүй Говь түшээ гүний хошууны Говь сангийн далайн хийд, Ар сангийн далай хийдийн буурин дээр одоог хүртэл үлдэж хоцорсон сүм дуганы үүд хаалганы хоёр ховор чухаг дурсгалыг чадлын хэрээр тодруулан тайлж уншаад олон нийтэд хүргэж байна. Энэ нь дөрвөлжин үсгийг монгол нутагт хожуу болтол хэрэглэсээр ирсний тодорхой баримт мөн бөгөөд төвөд хэлээр бичсэн сонирхолтой дурсгал болж үлджээ. Энэ мэт дурсгалыг манай залуу үеийнхэн анзааран энд тэндэхийн хуучин сүм, ном судраас хайгуулдан олшруулна гэдэгт итгэнэ.

#### Ном зүй:

**Шархүү, Ц.** (1984). *Дөрвөн аймгийн засаг хошуудын засаг ноёдын товч шастир*. Journal of Mongolian studies, №7. Edited by Mongol – kenkyukai. Osaka Japan. 119-210-р тал [Ts.Sharkhüü. *Dörvön aimgiin zasag khoshuudyn zasag noyodyn tovch shastir*. [Chronological Lists of the Names of the Princes of “Khoshuus” in “Dörbön Aimak”, 1984]

*Монголын хүрээ хийдийн түүх.* (2004). Эмхт. Ч.Банзрагч, Б.Сайнхүү. Уб., Соёмбо хэвлэлийн газар. [*Mongolyn khüree khiidiin tüükh*. [History of Mongolian Monasteries. Compiled by Banzragch, Ch., & Sainkhui, B. (Eds.). Ulaanbaatar: Soyombo Publishing House, 2004]

*Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны бум зарлиг хэмээгдэх оршив.* (1986). Эмхт. Галлуу, Жарантай. Монгол тулгар бичгийн цуврал. Үндэстний хэвлэлийн хороо. [*Mergen gegeen Luvsandambijaltsany bum zarlig khemeegdekh orshiv*. [The Hundred Thousand Decrees of the Wise Saint Luvsandambijaltsan. Compiled by Galluu & Jarantai (Eds.), Series of Mongolian Classical Scripts. Huhhot: Nationalilty Publishing Committee, 1986]



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>